# БАРИЛГА, БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ИННОВАЦ, ТЕХНОЛОГИ, НОГООН БАРИЛГЫН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН АХЛАХ ШИНЖЭЭЧ ДАРХИЖАВ ОВОГТОЙ БОЛОРМААГИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. “ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД”** | | | | | | | |
| 5.1. Барилга, барилгын материалын салбарын хууль тогтоомж, дүрэм, журмыг боловсронгуй болгох, бодлого, хөтөлбөр боловсруулах, зохион байгуулах, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хяналт тавих зорилтын хүрээнд: | | | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 5.1.13.** Уур амьсгалын өөрчлөлтийн Парисын хэлэлцээрт оруулах үндэсний тодорхойлсон хувь, нэмрийн хэрэгжилтийг хангана. **ЗГҮАХХҮТ /2024-2028/** | -Тайлан<br>-Арга хэмжээний санал | ЗГХЭГ-т хүргүүлсэн Олон улсын Парисын хэлэлцээрт салбарын чиглэлээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайлан 1. | Уур амьсгалын өөрчлөлтийн Парисын хэлэлцээрт оруулах үндэсний тодорхойлсон хувь, нэмрийн зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тус яамны хариуцах чиглэлээр тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, бусад холбогдох байгууллагатай хамтран ажиллаж, | 1.Монгол Улсын Уур амьсгалын өөрчлөлтийн 2 жил тутмын ил тод байдлын 1, 2-р тайлан, Үндэсний 4-р тайлан илтгэлд тусгах салбарын тайланг Уур амьсгалын өөрчлөлтийн хамтын ажиллагааны төвийн ccrccmongolia@gmail.com цахим хаягаар 2025.01.22-ны өдөр илгээсэн.<br>2.Нэгдсэн Үндэстний Байгууллагын Уур Амьсгалын Өөрчлөлтийн Суурь Конвенцын хэрэгжилтийн талаар Үндэсний тавдугаар тайлан илтгэл, хоёр жил тутмын ил тод байдлын 1, 2 дугаар тайлан (NC5/BTR1, 2) бэлтгэх ТУХ, УЗ-д БОУАӨЯ-нд 2025.02.19-ний өдрийн 01/647 болон 2025.02.27-ны өдрийн 01/795 тоот албан бичгээр нэр хүргүүлсэн.<br>3.“Агаарын бохирдлыг бууруулах хүрээнд утааны асуудлаарх бодлого, шийдвэрийн хэрэгжилтийн үр дүн, шийдэл” сэдвээр 2025 оны 02 дугаар сарын 03-04-ний өдрүүдэд зохион байгуулагдсан Ерөнхий хяналтын сонсголд сайдын тавих илтгэл, салбарын 2018-2024 онуудад | 2025.01.02-2025.12.15 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | салбарын 1 тайланг хүргүүлсэн байна. | хийгдсэн ажил, арга хэмжээний танилцуулга, холбогдох тайлан, мэдээллийг бэлтгэж Ж.Чинбүрэн УИХ-ын гишүүнд /УИХ-ын тамгын газарт/ 2025.01.22-ны өдрийн 01/232 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>4.Монгол Улсын тэргүүн шадар сайд бөгөөд ЭЗХ-ийн сайд, БОУАӨ-ийн сайдын 2025.01.21-ний өдрийн хамтарсан А/32/09 тушаалаар "Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг" байгуулагдсан. Тус ажлын хэсэгт гишүүнээр ажиллаж салбарын асуудлыг тусгах, хуулийн төслийг боловсруулахад хамтран ажилласан.<br>5.Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилт (ҮТХН буюу NDC)-ыг шинэчлэх ҮТХН3.0 -ыг боловсруулах үүрэг бүхий Үндсэн ажлын хэсэг болон Дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг БОУАӨ-ийн сайдын 2024.11.22-ны өдрийн А/807 тоот тушаалаар байгуулсан. Ажлын хэсэгт гишүүнээр, салбарын дэд ажлын хэсэгт нарийн бичгийн даргаар ажиллаж, Засгийн газрын 2025 оны 91 дүгээр тогтоолоор батлуулахад дэмжлэг үзүүлж, ЗГ-ын тогтоолын төсөлд өгөх саналыг 2025.09.04-ний өдрийн 01/335 тоот албан бичгээр хүргүүлсэн. | | |
| | **Арга хэмжээ 5.1.14:** Барилгын салбарын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна. | Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний тоо, хэрэгжилтийн хувь | 2024 онд БХБЯ-ны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 39 арга хэмжээг тусган хэрэгжүүлсэн. Арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн биелэлт 100% | “Барилга, хот байгуулалтын салбарын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө”-нд туссан, тус газрын хэрэгжүүлэх арга | -“Салбарын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө”-г хэрэгжүүлэхэд чиглэсэн 22 арга хэмжээг яамны нэгжүүдийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгуулсан.<br>-Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хөтөлбөрт тусгагдсан тус яамны хариуцан хэрэгжүүлж буй ажлын хэрэгжилтийг 2025 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн | 2025.01.02-2025.12.15 | 100% |

100

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулсан байна. | байдлаар гарган БОУАӨЯ-нд 2025.08.19-ний өдрийн 02/3083 тоот албан бичгээр хүргүүлсэн. Мөн хөтөлбөрийн хэрэгжилт, цаашид авах арга хэмжээний талаарх хэлэлцүүлэгт 2025.08.29-ний өдөр оролцож, салбарын зүгээс тайлбар гаргаж, танилцуулга хийсэн.<br>-Япон Улсын Засгийн газраас Монгол Улсад олгох буцалтгүй тусламжийн хүрээнд хэрэгждэг “Эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжих хөтөлбөр”-өөр 2027 оны санхүүгийн жилд Монгол Улсад хэрэгжүүлэх санал тусгуулахаар дараах төслийн саналыг 2025.01.21-ний өдрийн 03/224 тоот албан бичгээр хүргүүлсэн. Үүнд:<br>1.Гэр хорооллын хэсэгчилсэн инженерийн хангамжийн эх үүсвэрт байглийн нөөцийг ашиглах төсөл;<br>2.Дулааны цахилгаан станцаас гарах хаягдал /үнс, шаарга/-ыг боловсруулан барилгын материалын түүхий эд болгон ашиглах /технологи, орц, норм/ судалгаа;<br>3.Нар, салхины эх үүсвэр ашиглан гэр хорооллын өрхийг дулаанаар хангах төсөл;<br>4.Ногоон барилгын материалыг тодорхойлох, зардал, үр өгөөжийн тооцооллын судалгаа;<br>5.Боловсон хүчний чадавхийг нэмэгдүүлэх, чадавхжуулах сургалт;<br>Мөн салбарын хөгжилд нэн шаардлагатай 12 тоног төхөөрөмжийн саналыг загварын дагуу гарган хавсралтаар хүргүүлсэн.<br><br>-“Ногоон барилгын үнэлгээ (Bestger)-ний аргачлал”-ыг холбогдох журмын дагуу хэрэгжүүлэх ажлын хүрээнд | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | даpаах арга хэмжээг авч ажиллаж байна. Үүнд:<br>- Амины орон сууцны мэдээллийн төвөөс Жижиг, дунд үйлдвэрлэгч, барилгын бригадуудад зориулан зохион байгуулсан "Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны чадавхижуулах сургалт" 2025 оны 03 дугаар сарын 20, 21, 22-ны өдөр "Ногоон барилгын үнэлгээ (Bestger)-ний аргачлал", "Ногоон барилгын (BESTGER) гэрчилгээ олгох журам" болон "Барилгын материалын үйлдвэрлэлийн өнөөгийн байдал, баримталж буй бодлого, тогтвортой, ногоон үйлдвэрлэл, бүтээгдэхүүн" сэдвээр мэдээлэл өгч оролцсон;<br>- Иргэдэд зориулсан эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны зөвлөгөө, мэдээллийн нээлттэй өдөрлөгийг 2025.01.18, 2025.03.17-19, 2025.03.05, 2025.04.04, 2025.05.15-ны өдрүүдэд зохион байгуулсан.<br>- "Ногоон барилгын хүрээлэн" ТББ-аас Дархан, Эрдэнэт, Өвөрхангай, Хэнтий, Сүхбаатар аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын инженер, техникийн ажилчид болон ААНБ-дад "Ногоон барилгын үнэлгээ (Bestger)-ний аргачлал", "Ногоон барилгын (BESTGER) гэрчилгээ олгох журам"-ийн талаар мэдлэг, мэдээлэл олгох сургалт зохион байгуулсан;<br>-Сөүлийн Үндэсний Их Сургуулиас хэрэгжүүлж буй S-Quad төслийн хүрээнд байгальд ээлтэй, ногоон барилгын үнэлгээ, гэрчилгээжүүлэх, бодлогын баримт бичигт тусгах талаар БНСУ-ын туршлагад үндэслэн Солонгос улсын Бүтээмжийн төвийн чанарын баталгаажуулалтын газрын | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | захирал, албан хаагч нар 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр яамны Хурлын танхимд мэдээлэл хийж, яамны болон харьяа байгууллага, төрийн бус байгууллага, зураг төсөл зохиогч аж ахуйн нэгж, их сургуулийн судлаач нар оролцсон.<br>-Ипотекийн 6%-ийн зээлийн журамд Ногоон барилгын үнэлгээний BestGER системээр үнэлэн олгосон гэрчилгээг үндэслэн зээл олгох өөрчлөлт оруулах боломжтой талаар Монгол банкны Санхүүгийн зах зээлийн газрын захирал, холбогдох мэргэжилтнүүд болон Монголын Ногоон барилгын хүрээлэнгийн төлөөлөлтэй хамт 2025.09.25-ны өдөр Монголбанкинд уулзалт хийсэн. Хамтын ажиллагааг өргөжүүлж, энэ ондоо багтаан журмын өөрчлөлтийг хийж, иргэдэд Ногоон зээлийг хувийн орон сууцанд олгож эхлүүлэхээр тохиролцсон.<br>-ААНОАТ-ын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.9 дэх хэсэгт заасан хөнгөлөлт эдлэх бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд тавигдах нийтлэг шаардлагыг тогтоож, түүнд хяналт тавих үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулах чиглэлээр ТЕГ-ын Хурлын танхимд 2025.10.16-ны өдөр зохион байгуулсан хэлэлцүүлэгт ХББОСЯ-ыг төлөөлж оролцож чиглэл авч, санал солилцсон. Салбарт хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төсөл, үйл ажиллагааны талаар хүсэлт ирүүлсэн “Хера холдинг” ХХК-д 2025.08.19-ний өдрийн 02/3083 дугаар албан бичгээр хариу хүргүүлсэн.<br>-ХББОС-ын Сайдын 2025 оны 105 дугаар тушаалаар баталсан “ААНОАТ-ын хөнгөлөлт эдлэх бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлага”-ын талаар мэдээлэл солилцож зөвлөгөө өгсөн. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Үүнд:<br>-Татварын мэргэшсэн зөвлөхүүдтэй уулзалт 2025.10.28-ны өдөр;<br>-“Вертекс майнинг партнер” ХХК-ийн хуулийн албаны дарга болон мэргэжилтэнтэй хийсэн уулзалт 2025.10.29-ний өдөр. | | |
| | **Арга хэмжээ 5.1.15:** Барилгын хүлэмжийн хийн ялгарлын хэмжээг тоолох, цахим системийн үйл ажиллагааны чиглэлээр чадавхжуулах сургалт зохион байгуулсан байна. | Сургалтын хөтөлбөр 1 | 0 | Барилгын салбарын хүлэмжийн хийн тооллогын цахим системийн үйл ажиллагааг сайжруулах, хөтлөх, бүрдүүлэх чиглэлээр зохион байгуулах сургалтын хөтөлбөр боловсруулж, зохион байгуулсан байна. | Барилгын ХХЯ-ын хэмжээг тоолох цахим системийг хөгжүүлэх, системийн талаарх салбарын болон хангагч байгууллагуудын мэргэжилтнүүдийн чадавхийг дээшлүүлэх сургалт, хэлэлцүүлгийг 2025.12.05-ны өдөр Корпорайт зочид НҮБХХ-ийн "Уур амьсгалын амлалт 2" төсөлтэй хамтран зохион байгуулж, 30 гаруй мэргэжилтэн оролцож, системийн хөгжүүлэлт, найдвартай ажиллагаа, мэдээллийн эрэлт, нийлүүлэлтийн талаар хэлэлцүүлсэн. Сургалтын тайланг бичиж НҮБХХ-т илгээсэн. | 2025.01.02-2025.12.15 | 100% |
| | **Арга хэмжээ 5.1.16:** Ногоон барилгын чиглэлээр салбарын төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжтэй хамтын ажиллагааг өргөжүүлнэ | Хамтран ажиллаж дэмжлэг үзүүлсэн Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллагын тоо | СХД-ийн Амины орон сууцны мэдээллийн төвийн нээлтийг 2024 оны 12 дугаар сард хийсэн. | Салбарын аж ахуйн нэгж байгууллагатай хүлэмжийн хийн ялгарал багатай, эрчим хүчний хэмнэлттэй, шинэ инновац, технологи нэвтрүүлсэн, импортолсон болон эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр хамтран ажиллана. | 1.Эрчим хүчний хэмнэлттэй, хөрс, агаар орчны бохирдолгүй ногоон барилгын шаардлагад нийцсэн барилгын дэвшилтэт технологийн шийдлүүдийг нэг дороос сонгох боломжийг бүрдүүлсэн "Амины орон сууцны мэдээллийн төв"ийг байгуулах тендерийг нээлттэй зарласан. Тендерт шалгарсан “Амины орон сууны инновац, хөгжлийн төв”-тэй 3 байршилд буюу ЧД, СХД, БЗД-ийн төвүүдийг байгуулах, үйл ажиллагааг хангахаар тус яамтай гэрээ байгуулан ажиллаж байна.<br>"Амины орон сууцны мэдээллийн төв"-үүд нь СХД-ийнх 2024.12.18, БЗД-ийн төв нь 2025.02.10, ЧД-ийн төв нь 2025.04.28-ны өдөр нээлтээ хийсэн. Тус төвүүдэд барилгын салбарт ногоон технологи | 2025.01.02-2025.12.15 | ~~100%~~<br>80% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | нутагшуулагч 80 гаруй байгууллагын үзүүлэнгийн хэсэг, оффис байрлан ажиллаж байна. Эдгээр төвүүд нь нээлтээ хийсэн өдрөөс хойш давхардсан тоогоор 5000 гаруй иргэдэд мэргэжлийн зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллаж байна.<br>2.Засгийн газрын “Агаарын бохирдлыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” 2025 оны 133 дугаар тогтоолыг хэрэгжилтийг хангах хүрээнд Эрчим хүчний хэмнэлттэй, дулаан алдагдалгүй, тэсвэртэй, ногоон амины орон сууц барих, нөхцөл сайжруулах, дулаалах дэвшилтэт технологийн шийдлүүдийг иргэдэд сурталчлан танилцуулах, оролцогч байгууллагуудын уялдааг хангах зорилгоор “Дулаан байшин” Амины орон сууцны өдөрлөгийг БОУАӨЯ, ЭХЯ, НЗДТГ-тай хамтран Сүхбаатарын талбай дээр 2025.05.05-07-ны өдрүүдэд зохион байгуулсан. Энэхүү өдөрлөгт 82 бүүт ажиллуулж, үндсэн 4 чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч ААН байгууллагуудыг байрлуулж, хэсэг болгосон. Тус өдөрлөгт салбарын төрийн бус байгууллага, аж ахуй нэгж байгууллага, олон улсын байгууллагын төлөөлөл, банк санхүүгийн салбарын нийт 91 байгууллагын төлөөлөл оролцож нийт 10,000 орчим, давхардсан тоогоор 29,562 иргэнд эрчим хүчний хэмнэлттэй, дулаан алдагдалгүй, тэсвэртэй, ногоон амины орон сууц барих, нөхцөл сайжруулах, дулаалах дэвшилтэт технологийн шийдлүүдийг танилцуулсан.<br>Оролцогч байгууллагууд нь 241 ажил үйлчилгээ үзүүлэх, худалдах гэрээ; 187 бараа, бүтээгдэхүүний худалдаа хийсэн байна.<br>Хэсгүүдэд байрлах мэдээллийн хэсэгт нийт 31 илтгэл, өдөрт | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дунджаар 2 удаагийн давтамжтай танилцуулагдлаа.<br>Нэгдсэн мэдээллийн дэлгэцээр нийт 75 аж ахуй нэгж байгууллагын бүтээгдэхүүн үйлчилгээний танилцуулга шторк өдөрт дунджаар 3 удаагийн давтамжтай танилцуулагдлаа.<br>Өдөрлөгт оролцогч аж ахуй нэгж байгууллагуудаас авсан сэтгэл ханамжийн судалгаанд нийт оролцогсдын 75.8% буюу 69 аж ахуй нэгж байгууллага хамрагдсан.<br>-Үүрэг хүлээсэн хэрэглэгчийн эрчим хүчний хэрэглээний босго хэмжээг шинэчлэн боловсруулах Ажлын хэсгийг Эрчим хүчний зохицуулах хорооны даргын 2025 оны А/60 дугаар тушаалаар байгуулсан. АХ-ийн 3 удаагийн хуралд оролцож шаардлагатай мэдээлэл цуглуулах, солилцох, босго үнийн үндэслэлийг шинээр тодорхойлох талаар АХ-ийн төлөвлөгөө гаргасан. | | |
| 5.2. Барилга, барилгын материалын салбарын төсөл, хөтөлбөрийг зохион байгуулах, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хяналт тавих зорилтын хүрээнд: | | | | | | | |
| | **Арга хэмжээ 5.2.9:** “Ногоон барилгын үнэлгээ (BESTGER)-ний аргачлал”, “Ногоон барилгын (BestGER) гэрчилгээ олгох журам”-ыг салбарын инженер техникийн ажилчдад сургалт зохион байгуулна. /ЗГҮАХХАХТ-ний 3.4.3.7.1009, 1010/ | ШҮ-1: Сургалт, тоо-2<br>ШҮ-2: Сургалтад хамрагдсан эксперт, тоо | ХББОС-ын сайдын 2024 оны 108 дугаар тушаал “Ногоон барилгын үнэлгээ (BESTGER)-ний аргачлал”, 2024 оны 153 дугаар тушаал “Ногоон барилгын (BestGER) гэрчилгээ олгох журам” | Салбарын ИТА-ын мэргэжлийн зэрэг горилох, мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрт багц цагаар тусган зохион байгуулсан байна. | ХББОС-ын сайдын 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 74 дүгээр тушаалаар “Ногоон барилгын үнэлгээ (Bestger)-ний аргачлал, “Ногоон барилгын (Bestger) гэрчилгээ олгох журам”-ийг сурталчлан таниулах ажлын хэсэг байгуулсан. Ажлын хэсгээс хэвлэл мэдээлэл, олон нийтийн ТВ-ийн хэлэлцүүлэг хийх ажлыг зохион байгуулсан.<br>- “Ногоон барилгын хүрээлэн” ТББ-аас Дархан, Эрдэнэт, Өвөрхангай, Хэнтий, Сүхбаатар аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын инженер, техникийн ажилчид болон ААНБ-дад “Ногоон барилгын үнэлгээ (Bestger)-ний аргачлал”, “Ногоон барилгын (BESTGER) гэрчилгээ | 2025.08.02-2025.12.15 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | олгох журам"-ийн талаар мэдлэг, мэдээлэл олгох сургалт зохион байгуулсан;<br>-Ногоон барилгын аудитор бэлтгэх сургалтыг 2025 оны 10 дугаар сард зохион байгуулж, шалгалтад тэнцсэн 11 аудиторт тус яамны ТНбД-ын А/158 дугаар тушаалаар гэрчилгээ олгосон.<br>-Үндэсний Итгэмжлэлийн Төвтэй хамтран "Ногоон барилга-Ногоон санхүүжилт-Баталгаажуулалт" сэдэвт хэлэлцүүлгийг 2025.12.03-ны өдөр хамтран зохион байгуулж, ногоон барилгын үнэлгээний систем, Ногоон барилгын үнэлгээ (BESTGER)-ний аргачлал, гэрчилгээ олгох аудитор, сургагч багш талаар танилцуулга хийж, хамтын ажиллагааны чиглэлийг нарийвчлан тодорхойлох, баталгаажуулалтын хүрээг нэмэгдүүлэх, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн баталгаажуулалтыг бий болгох чиглэлээр хэлэлцүүлсэн | | |
| | **Арга хэмжээ 5.2.14:** Үндэсний ногоон барилгын үнэлгээний системийг нэвтрүүлж, хөгжүүлэх /ЗГҮАХХАХТ-ний 3.4.3.7.1011 | Ажлын даалгавар, тоо -1 | 0 | Ажлын даалгавар боловсруулж батлуулах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан байна. | "Ногоон барилгын үнэлгээ (Bestger)-ний аргачлал"-д үндэслэн үндсэн өгөгдлүүдийг оруулж, эрх бүхий Ногоон барилгын аудиторуудын үнэлгээний дүгнэлт бүртгэгдсэнээр Гэрчилгээг цахимаар олгох үйл ажиллагааны цар хүрээг тогтоож, "Ногоон барилгын үнэлгээний систем"-ийг бий болгохоор техникийн даалгаварын төслийг боловсруулсан, батлагдах шатанд байна. ББННС-ын 2026 оны үйл ажилллагааны төлөвлөгөөнд тусгуулахаар ажиллаж байна. Мөн Үндэсний Итгэмжлэлийн Төвтэй хамтран баталгаажуулалтын хүрээг нэмэгдүүлэх, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн баталгаажуулалтыг бий болгох чиглэлээр "Ногоон барилга-Ногоон санхүүжилт-Баталгаажуулалт" сэдэвт хэлэлцүүлгийг 2025.12.03-ны өдөр хамтран зохион байгуулж, ногоон | 2025.01.02-2025.12.15 | 30% ✓ |

103

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | барилгын үнэлгээний системийн талаар илтгэл тавьж, танилцуулга хийсэн. Цаашдын хамтын ажиллагааны чиглэлийг нарийвчлан тодорхойлох талаар хэлэлцүүлсэн. | | |
| 5.4. Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих зорилтын хүрээнд: | | | | | | | |
| | **Арга хэмжээ 5.4.9:** "Пассив барилгын стандартын шаардлага"-ийг боловсруулах ажлын даалгаварыг боловсруулах, батлуулах /ЗГҮАХХАХТ-ний 1.1.3.7/ | Ажлын даалгавар, тоо-1, | 0 | Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа стандарт, норм дүрмийг Олон улсын мөрдөж буй пассив барилгын стандартад нийцүүлэх шаардлагыг боловсруулах Ажлын даалгаврыг боловсруулах ажлыг зохион байгуулна. | 1.Пассив барилгын барилгын стандартын шаардлага боловсруулах ажлын техникийн даалгаврын төслийг боловсруулж, санал авахаар viber системээр "Пассив барилгын хүрээлэн" ТББ-д хүргүүлж, 2025.12.18-ны өдрийн 35 тоот албан бичгээр санал ирүүлсэн. Техникийн даалгавар батлуулснаар ажлын тоо хэмжээ тодорхой болж төсөв гарна. Барилга, хот байгуулалтын сайд, Эрчим хүчний сайдын хамтарсан 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн А/257, А/252 дугаартай тушаалаар батлагдсан "Барилгын эрчим хүчний гэрчилгээ олгох журам"-ын дагуу 319 барилгын зураг төсөлд 2025 оны эхний хагас жилийн байдлаар орон тооны бус экспертүүдээр хянагдаж, эрчим хүчний гэрчилгээ олгогдсон.<br>2.Япон Улсын барилга, орон сууцны эрчим хүчний хэмнэлт, пассив болон ногоон барилга байгууламжид хэрэгжүүлж байгаа бодлого, норм норматив, техникийн зохицуулалт, стандарт, арга хэмжээ, ач холбогдол, үр нөлөөг судлах болон шинэ технологи, инновац, шилдэг жишээтэй танилцаж, туршлага судлах зорилгоор 2025 оны 12 дугаар сарын 06-14-ний өдрүүдэд томилолтоор ажиллах багийн бүрэлдэхүүн, удирдамжийг ТНбД-ын 2025.11.28-ны өдрийн Б/204 тоот тушаалаар баталсан. Тус баг нь ХББОСЯ, Барилгын хөгжлийн төв, Нийслэлийн ЗДТГ, МУИС-ийн багш, судлаач нараас бүрдсэн. Энэхүү арга хэмжээний үр дүнд барилгын эрчим | 2025.08.01-2025.12.15 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хүчний хэмнэлт, пассив болон ногоон барилгын талаарх Японы туршлага, инновацийн шийдлүүдийг судалж, Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй норматив баримт бичгүүдтэй уялдуулах, нутагшуулах боломжийг тодорхойлон, норм норматив, стандартыг шинэчлэх, бодлогын баримт бичигт тусгах талаар салбарын мэргэжилтнүүд шинэ мэдлэг, ойлголт, ур чадвараа дээшлүүлсэн. | | |
| **Зорилт 2. “ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ”** | | | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 3.1:** Дээд шатны байгууллага, бусад яамд, холбогдох газруудаас санаачлан боловсруулсан хууль тогтоомж, бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдэд санал өгч, салбар хоорондын зохицуулалтыг хангаж ажиллана. | - саналын тоо,<br>оролцсон арга хэмжээний тоо | | | Дээд шатны байгууллага, бусад яамд, холбогдох газруудаас санаачлан батлуулсан хууль тогтоомж, бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдийн манай салбарын чиг үүрэгт хамаарах асуудал, арга хэмжээний биелэлтийг хугацаанд нь гарган хүргүүлэв.<br>• “Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт ”/БОУАӨЯ-нд 2025-04-09-ний өдрийн 03/1247 тоот/<br>• Монгол Улсын Уур амьсгалын өөрчлөлтийн 2 жил тутмын ил тод байдлын 1, 2-р тайлан, Үндэсний 4-р тайлан илтгэлд тусгах салбарын тайланг Уур амьсгалын өөрчлөлтийн хамтын ажиллагааны төвийн ccrccmongolia@gmail.com цахим хаягаар 2025.01.22-ны өдөр илгээсэн.<br>• Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хөтөлбөрт тусгагдсан тус | 2025.01.02-2025.12.15 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | яамны хариуцан хэрэгжүүлж буй ажлын хэрэгжилтийг 2025 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар гарган БОУАӨЯ-нд 2025.08.19-ний өдрийн 02/3083 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>• “Ногоон санхүүжилтын тогтолцоог бүрдүүлэх, эрх зүйн орчныг сайжруулах талаар авах арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын 2025 оны 57 дугаар тогтоолын хэрэгжилтийг гарган 2025.11.20-ны өдрийн 02/4298 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>• Хятад-Монголын цөлжилттэй тэмцэх хамтын ажиллагааны төв, туршилтын талбай байгуулах ТЭЗҮ боловсруулахад нэмж тусгах саналыг 2025.12.04-ний өдрийн 01/4499 тоот албан бичгээр хүргүүлсэн<br>Бусад яамд, газраас боловсруулсан Улсын Их хурлын болон Засгийн газрын тогтоолын төслүүдэд албан бичгээр хариу хүргүүлсэн. Үүнд:<br>• “Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” /ЗГХЭГ-нд 2025-04-10-ны өдрийн 01/1252 тоот/;<br>• “Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг шинэчлэн батлах тухай” /БОУАӨЯ-нд 2025-09-04-ний өдрийн 01/3395 тоот/;<br>• “Инновацын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл (2025-2030)” /ЦХИХХЯ-нд 2025-10-20-ны | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | өдрийн 02/3892 тоот/;<br>• "Шинжлэх ухаан, технологи, инновацын үндэсний хорооны бүрэлдэхүүн, дүрэм, ажиллах журам батлах тухай" /ЭЗХЯ-нд 2025-10-21-ний өдрийн 01/3914 тоот/;<br>• Хятад-Монголын цөлжилттэй тэмцэх хамтын ажиллагааны төв, туршилтын талбай байгуулах ТЭЗҮ боловсруулахад нэмж тусгах саналыг 2025.12.04-ний өдрийн 01/4499 тоот албан бичгээр хүргүүлсэн. | | |
| 2. | **Арга хэмжээ 3.2:** Хариуцсан асуудлаар дээд шатны байгууллага, удирдлага, холбогдох байгууллага, иргэдийг бодит мэдээ, мэдээллээр хангаж ажиллана. | -тоо | | | - Ёс зүйн дэд хороонд ЗГХХГ-ын 2025.02.27-ны өдрийн 04/274 тоот бичгээр ирүүлсэн гомдлын дагуу тус яамны СХГ-ын албан хаагчдад гаргасан өргөдөлд дүгнэлт гарган 2025.04.02-н өдрийн 13/1114 тоот албан бичгээр хариу хүргүүлсэн.<br>- иргэн Ц.Дондогоос гаргасан гомдлын дагуу асуудлыг шийдвэрлэн Ёс зүйн дэд хорооны дүгнэлт гаргаж хүргүүлсэн. Цахим системд бүртгэгдсэн.<br>- Иргэн Н.Ариунболдын хүсэлтийн дагуу 2025.08.20-ны өдрийн 02/3114 тоот албан бичгээр мэдээлэл хүргүүлсэн. | 2025.01.02-2025.12.15 | 100% |
| 3. | **Арга хэмжээ 3.3:** Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг чанд сахих, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах. | Ёс зүй, ашиг сонирхлын зөрчлийн тоо | | | - Хөтлөх нэрийн жагсаалтын дагуу газар, нэгжийн албан хаагчдын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайланг архивын нэгж болгон хүлээлгэн өгсөн.<br>- Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/32 тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны материал, тендерийн баримт бичиг, | 2025.01.02-2025.12.15 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | холбогдох материалыг архивын нэгж үүсгэн архивт хүлээлгэн өгсөн.<br>- Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө 2025-ын ажлын хэсгийн холбогдох материалыг архивын нэгж үүсгэсэн. | | |
| 4 | **Арга хэмжээ 3.4:** Хариуцсан асуудалтай холбоотой ирүүлсэн албан бичиг төлөвлөж явуулах, ирсэн бичигт хариу төлөвлөх, хүргүүлэх | Албан бичиг, өргөдөл, гомдол тоо | | | Хариуцсан асуудалтай холбоотой 49 албан бичиг ирсэн байна. Мөн 39 албан бичгийг холбогдох хууль тогтоомж, стандартад нийцүүлэн боловсруулж холбогдох байгууллага, иргэнд хүргүүлсэн байна. | 2025.01.02-2025.12.15 | 100% |

## Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн А/12 дугаар тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны нарийн бичгийн даргаар ажиллах | | | | “Сумын төвийн инженерийн шугам сүлжээний 2 дугаар ээлжийн ажил /Баянхонгор аймаг, Өлзийт сум/” ХББОСЯ/20250101003 дугаартай тендерийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тенперийг хуулийн хүрээнд зохион байгуулж Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан ТНбД-д зөвлөмж хүргүүлсэн. Тендерийн баримт бичгийг Архивын нэгж болгон хүлээлгэн өгсөн. | 2025.02.01-2025.12.15 | 100% |

112

### Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | **Арга хэмжээ 1.**<br>Төрийн албаны тухай хууль, салбарын бусад хууль тогтоомж, тэдгээрийг дагалдан гарсан дүрэм, журмыг судлах, мэргэшүүлэх болон чадавхжуулах сургалтад хамрагдсан байна. | Сургалт, тоо | | | 1. Пүрэв гараг бүрт ТАЗ болон Удирдлагын академиас хамтран зохион байгуулагдсан сургалтад мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилгоор тасралтгүй хамрагдахыг зорьж оролцдог.<br>2. “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль,/2023 оны 05 дугаар сарын 04-ний өдөр/<br>3. "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам" /2024 оны 02 дугаар сарын 19-ний өдөр батлагсан./ | 2025.01.02-2025.12.15 | 100% |
| 2. | **Арга хэмжээ 2.**<br>Хариуцсан асуудлын хүрээнд урт, богино хугацааны сургалтад хамрагдаж, мэдлэг чадвараа дээшлүүлсэн байна. | Сургалт, тоо | | | Дараах сургалт, семинарт оролцсон. Үүнд:<br>- “Монголын Улсын Үндэсний тодорхойлсон хувь нэмэрт жендэрийн эрх тэгш байдлыг тусгах нь сургалт семинар”-т хамрагдсан.<br>- Удирдлагын академиас зохион байгуулсан **“Төрийн захиргааны байгууллагын стратеги төлөвлөлт”** сэдэвт богино хугацааны сургалтад 2025.02.17, 19-ны өдрүүдэд амжилттай хамрагдсан.<br>- “Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотын хотжилтын тогтвортой байдлыг хангах, | 2025.01.02-2025.12.15 | 100% |

113

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бүс нутгийн тэнцвэртэй хөгжлийг дэмжих төсөл"-ийн хүрээнд чадавхжуулах сургалт-семинарт 2025.05.18-24-ний өдрүүдэд оролцож, мэргэжил дээшлүүлсэн.<br>- Төрийн албан дахь ёс зүйн төлөв байдлыг тандах судалгаа, ёс зүйн зөрчилд өртөх эрсдлийн үнэлгээ"-ний сургалтад 2025.12.19-ний өдөр хамрагдсан. | | |
| 3. | **Арга хэмжээ 3**. Үйл ажиллагаатай холбоотой хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлж ЗГ, УИХ-ын тогтоол, хуулийн шийдвэртэй цаг тухайд нь танилцсан байна. | Сургалт, тоо | | | Шинээр батлагдан гарсан, салбарын үйл ажиллагаанд шууд болон шууд бус байдлаар ашигладаг хууль тогтоомж, УИХ, ЗГ-ийн шийдвэр, сайдын тушаалаар батлагдсан дүрэм, журамтай танилцсан. | 2025.01.02-2025.12.15 | 100% |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

Ахлах шинжээч — Д.Болормаа .................................. — 2025.12.05 ..................

*(Албан тушаал)* — *(Нэр, гарын үсэг)* — *(Огноо)*

# БАРИЛГА, БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН АХЛАХ ШИНЖЭЭЧ ДАРХИЖАВ ОВОГТОЙ БОЛОРМААГИЙН 2025 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС (ГҮЙЦЭТГЭХ АЛБАН ТУШААЛТАН)

Байгууллагын нэр: ...**Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам**

Нэгжийн нэр: ...**Барилга, барилгын материалын бодлого, зохицуулалтын газар.**

## 1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо | Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал | Нийлбэр оноо | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Оноо | 60 хүртэл | 10 хүртэл | 70 хүртэл | |
| **Зорилт 1 "ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД"-ийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт** | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 5.1.13.** Уур амьсгалын өөрчлөлтийн Парисын хэлэлцээрт оруулах үндэсний тодорхойлсон хувь, нэмрийн хэрэгжилтийг хангана. **ЗГҮАХХҮТ /2024-2028/** | 60 | 10 | 70 ✓ | |
| 2 | **Арга хэмжээ 5.1.14:** Барилгын салбарын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна. | 60 | 10 | 70 ✓ | |
| 3 | **Арга хэмжээ 5.1.15:** Барилгын хүлэмжийн хийн ялгарлын хэмжээг тоолох, цахим системийн үйл ажиллагааны чиглэлээр чадавхжуулах сургалт зохион байгуулсан байна. | 60 | 10 | 70 ✓ | |
| 4 | **Арга хэмжээ 5.1.16:** Ногоон барилгын чиглэлээр салбарын төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжтэй хамтын ажиллагааг өргөжүүлнэ | ~~60~~ 48 | 10 | ~~70~~ 58 | |
| 5 | **Арга хэмжээ 5.2.9:** "Ногоон барилгын үнэлгээ (BESTGER)-ний аргачлал", "Ногоон барилгын (BestGER) гэрчилгээ олгох журам"-ыг салбарын инженер техникийн ажилчдад сургалт зохион байгуулна. /ЗГҮАХХАХТ-ний 3.4.3.7.1009, 1010/ | 60 | 10 | 70 ✓ | |
| 6 | **Арга хэмжээ 5.2.14:** Үндэсний ногоон барилгын үнэлгээний системийг нэвтрүүлж, хөгжүүлэх /ЗГҮАХХАХТ-ний 3.4.3.7.1011 | ~~25~~ 18 | 5 | ~~30~~ 23 ✓ | |
| 7 | **Арга хэмжээ 5.4.9:** "Пассив барилгын стандартын шаардлага"-ийг боловсруулах ажлын даалгаварыг боловсруулах, батлуулах /ЗГҮАХХАХТ-ний 1.1.3.7/ | 60 | 10 | 70 ✓ | |
| **Зорилт 3. ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ -ийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт** | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 3.1:** Дээд шатны байгууллага, бусад яамд, холбогдох газруудаас санаачлан боловсруулсан хууль тогтоомж, бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдэд санал өгч, салбар хоорондын зохицуулалтыг хангаж ажиллана. | 60 | 10 | 70 ✓ | |
| 2. | **Арга хэмжээ 3.2:** Хариуцсан асуудлаар дээд шатны байгууллага, удирдлага, | 60 | 10 | 70 ✓ | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | холбогдох байгууллага, иргэдийг бодит мэдээ, мэдээллээр хангаж ажиллана. | | | | |
| 3. | **Арга хэмжээ 3.3:** Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг чанд сахих, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах. | 60 | 10 | 70 ✓ | |
| 4 | **Арга хэмжээ 3.4:** Хариуцсан асуудалтай холбоотой ирүүлсэн албан бичиг төлөвлөж явуулах, ирсэн бичигт хариу төлөвлөх, хүргүүлэх | 60 | 10 | 70 ✓ | |
| **Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт** | | | | | |
| 1. | ХББОС-ын сайдын 2025 оны А/12 дугаар тушаалаар байгуулагдсан Үнэлгээний хорооны нарийн бичгийн даргаар ажиллах | 60 | 10 | 70 ✓ | |
| **Дундаж оноо:** | | | | ~~66,6~~ 65,1 | |

2. **Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Нийт (15 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 1. | **Арга хэмжээ 1.** Төрийн албаны тухай хууль, салбарын бусад хууль тогтоомж, тэдгээрийг дагалдан гарсан дүрэм, журмыг судлах, мэргэшүүлэх болон чадавхжуулах сургалтад хамрагдсан байна. | 100 | 15 | |
| 2. | **Арга хэмжээ 2.** Хариуцсан асуудлын хүрээнд урт, богино хугацааны сургалтад хамрагдаж, мэдлэг чадвараа дээшлүүлсэн байна. | 100 | 15 | |
| 3. | **Арга хэмжээ 3**. Үйл ажиллагаатай холбоотой хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлж ЗГ, УИХ-ын тогтоол, хуулийн шийдвэртэй цаг тухайд нь танилцсан байна. | 100 | 15 | |
| **Дундаж оноо** | | | 15 | |

3. **Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Нэгжийн даргын үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 |
| **1.** | Хандлага, ёс зүй | 7 | |
| 2. | Дүн шинжилгээ хийх | 7 | |
| 3. | Асуудал шийдвэрлэх | 7 | |
| **4.** | Хариуцлагатай байдал | 7 | |
| 5. | Ажлын цаг ашиглалт | 7 | |
| | Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | |
| 6. | Мэргэжлийн ур чадвар 1. | 7 | |
| **7.** | Мэргэжпийн ур чадвар 2. | 7 | |
| 8. | Мэргэжлийн ур чадвар 3. | 7 | |
| | **Дундаж оноо** | 7 | |

4. **Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Хамт олны үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Хамт олны үнэлгээ (0-8 оноо) |
|---|---|---|
| | 1 | 2 |
| **1.** | Хандлага, ёс зүй | 8 |
| 2. | Багаар ажиллах | 8 |
| 3. | Харилцаа | 8 |
| | **Дундаж оноо** | 8 |

**5.Гүйцэтгэлийн үнэлгээ**

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)* | *(70 хүртэлх оноо)* ~~66,6~~ 65,1 |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | *(15 хүртэлх оноо)* 15 |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Нэгжийн даргын үнэлгээ)* | *(7 хүртэлх оноо)* 7 |
| 4. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Хамт олны үнэлгээ)* | *(8 хүртэлх оноо)* 8 |
| 5. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт *(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | *(..... оноо)* |
| | **Нийт оноо =** ( Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо *(Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)*) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо | ~~96,6~~ 95,1 |

***Үнэлгээ өгсөн:***

ББМБЗГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч ..................... (Д.Энхбаатар) 10/XII. 2025

*( Албан тушаал)* *( гарын үсэг, албан хаагчийн нэр )* *(огноо )*

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:*** ***Төрийн жинхэнэ албан хаагч:***

ББМБЗГ-ын ахлах шинжээч ........................ (Д.Болормаа ) ...................
*( Албан тушаал)* *( гарын үсэг, албан хаагчийн нэр )* *(огноо )*

***Үнэлгээг хянасан:***

*Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:*

**........................** **......................** **..................**
*( Албан тушаал)* *( гарын үсэг, албан хаагчийн нэр )* *(огноо )*

*Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:*

**........................** **......................** **..................**
*( Албан тушаал)* *( гарын үсэг, албан хаагчийн нэр )* *(огноо )*

***Үнэлгээг баталгаажуулсан: Төсвийн шууд захирагч***

Төрийн нарийн бичгийн даргын
албан үүргийг түр орлон гүйцэтгэгч ........................ ( М.Баяраа ) ...................
*( Албан тушаал)* *( гарын үсэг, албан хаагчийн нэр )* *(огноо )*